



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 279

Улаанбаатар хот

### ┌ Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох ┐ тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/12 дугаар тогтоол, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 75 дугаар тогтоол, Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 424,962,033.00 (дөрвөн зуун хорин дөрвөн сая есөн зуун жаран хоёр мянга гучин гурван) төгрөгийн балансын үнэ, 27,740,577.00 (хорин долоон сая долоон зуун дөчин мянга таван зуун далан долоон) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгө (барилга)-ийг 1 дүгээр хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст эзэмшүүлж, биет бус хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 23,100,000.00 (хорин гурван сая нэг зуун мянган) төгрөгийн үнэтэй, 1540 м.кв талбай бүхий газар-газар эзэмших эрхийг 2 дугаар хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Говьсүмбэр аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3. Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 294,900,000.00 (хоёр зуун ерэн дөрвөн сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэтэй, хөрөнгө (тээврийн хэрэгсэл)-ийг 3 дугаар хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

4. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

4.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

137005400

15-r\_huraldaan.docx

4.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;


4.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

5.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА




Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 03 дугаар сарын 20 ны өдрийн  
178 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ  
ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

| Д/д      | Үндсэн хөрөнгийн нэр | Ашиглалтад орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) |
|----------|----------------------|---------------------|-------------|------------|-----------------------|--------------------------------|-------------------------|
| 1        | Барилга              | 2016                | м2          | 580.2      | 424,962,033.00        | 27,740,577.00                  | 397,221,456.00          |
| Нийт дүн |                      |                     |             |            | 424,962,033.00        | 27,740,577.00                  | 397,221,456.00          |


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 02 дугаар сарын 09 ны өдрийн  
27 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

| Д/д      | Үндсэн хөрөнгийн нэр    | Ашиглалтад орсон он | Хэм жих нэгж | Тоо хэм жээ | Балансын үнэ (төгрөг) |
|----------|-------------------------|---------------------|--------------|-------------|-----------------------|
| 1        | Газар-газар эзэмших эрх | 2023                | м2           | 1540        | 23,100,000.00         |
| Нийт дүн |                         |                     |              |             | 23,100,000.00         |

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 09 дугаар сарын 29 ны өдрийн  
29 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН  
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ, ГАДААДЫН ИРГЭН,  
ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАРТ ЭЗЭМШҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

| Д/д      | Үндсэн хөрөнгийн нэр      | Ашиглалтад орсон он | Хэм жих нэгж | Тоо хэм жээ | Балансын үнэ (төгрөг) |
|----------|---------------------------|---------------------|--------------|-------------|-----------------------|
| 1        | Ниссан урбан, 09-72 УАМ   | 2022                | ш            | 1           | 84,900,000.00         |
| 2        | Ниссан сивилян, 57-06 УАЕ | 2022                | ш            | 1           | 210,000,000.00        |
| Нийт дүн |                           |                     |              |             | 294,900,000.00        |